



ХЭВЛЭЛ  
МЭДЭЭЛЛИЙН  
ЗӨВЛӨЛ

# СОНГУУЛИЙГ ЁС ЗҮЙТЭЙ СУРВАЛЖЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ



2020 он

# FRIEDRICH EBERT STIFTUNG

Уг зөвлөмжийг Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр хэвлэв. Агуулгыг Хэвлэл мэдээллийн зөвлөл хариуцах бөгөөд Фридрих-Эбертийн сангийн байр суурьд нийцэж байх албагүй болно.

## ӨМНӨХ ҮГ

### 1. СОНГУУЛИЙГ ЁС ЗҮЙТЭЙ СУРВАЛЖЛАХ НЬ

- Бэлтгэл ажиллагаа

### 2. АНХААРАХ ЗҮЙЛС

- Редакц юу анхаарах вэ?
- Сэтгүүлч юу анхаарах вэ?
- Худал мэдээлэл доромжлол гүтгэлэг тараахгүй байх
- Буруутгагдсан этгээдэд тайлбар өгөх боломж олгох
- Залруулга хийх, уучлалт хүсэх
- Төлбөртэй мэдээлэл, үзэл бодол, байр суурийг редакцын бүтээлээс ялгаж зааглах

### 3. ИРГЭНИЙ МЭДЭХ ЭРХ БА СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ

#### 4. ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

- Жендэрийн тэгш байдлыг хангах
- Эфир болон зай талбайн тэгш хуваарилалт

### 5. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕД СОШИАЛ МЕДИАГ АШИГЛАХ НЬ

- Редакц сошиал медиаг ашиглахдаа юуг анхаарах вэ?
- Сэтгүүлч сошиал медиаг ашиглахдаа юуг анхаарах вэ?

### 6. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ



Чингисийн өргөн чөлөө, СБД



976- 70000610



[www.mediacouncil.mn](http://www.mediacouncil.mn)



Хэвлэл мэдээллийн зөвлөл

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улс нь чөлөөт, шударга сонгуулиар дамжуулан төрийн үйл хэрэгт оролцох иргэн бүрийнхээ эрхийг олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжуудаараа баталгаажуулсан байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлд “Хүн бүр улс орноо удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй” хэмээн тунхагласан. Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн эрх бүх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн заасан байдаг.

Монгол Улс 1992 оноос хойш Улсын Их Хурлын найман удаагийн, Ерөнхийлөгчийн долоон удаагийн сонгуулийг тус тус зохион байгуулаад байна. Хамгийн сүүлд 2020 оны зургаадугаар сарын 24-нд УИХ-ын ээлжит сонгуулийг КОВИД-19 цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдалд хийсэн бол мөн оны аравдугаар сард нийслэл болон орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг хийнэ.

Төрийн эрх барих төлөөлөгчөө сонгох иргэний эрхийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн үүрэг, тэдний мэргэжлийн хүчин чармайлт асар их билээ. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн үеэр нэн ялангуяа сонгуулийн сурталчилгааны хугацаанд иргэдийг бодитой, баримттай, олон ургальч, тэнцвэртэй, нягталж шалгасан мэдээллээр хангаж, тэдэнд сонголтоо шударгаар эдлэх боломж олгосноороо ардчилсан сонгуульд үнэтэй хувь нэмэр оруулдаг.

Монголын сэтгүүлчдийн дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болох “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын хэрэгжилт сонгуулийн үед жирийн үеэс ч өндөрт тавигддаг. Учир нь сонгуулийн үед төлбөртэй пиар мэдээлэл болон редакцын бүтээлийн зааг ялгаа бүдгэрч, мэргэжлийн шүүмжлэлт сэтгүүл зүйн орон зай хумигдах эрсдэл тулгардаг. Түүнчлэн өрсөлдөгч нам, нэр дэвшигчдийн талаар мэдээлж сурвалжлахдаа тэдэнд тэгш боломж олгож, шударгаар ажиллахыг эрмэлзэх нь чухал юм.

Иймд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс нийт хэвлэл мэдээллийн байгууллагын редакторуудад зориулсан “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг”-ийг санаачлан боловсруулж, сэтгүүлч танд илгээж байна.

Энэхүү бодлогын баримт бичгийг бэлтгэсэн ХМЗ-ийн Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хорооны гишүүн О.Ариунбилэг болон хэвлэмэл хувилбарыг бэлтгэн гаргахад дэмжлэг үзүүлсэн Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт гүн талархал илэрхийлье.

ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа

# 1. СОНГУУЛИЙГ ЁС ЗҮЙТЭЙ СУРВАЛЖЛАХ НЬ:



Монгол Улс нь парламентын засаглалтай бөгөөд УИХ болон Орон нутгийн сонгууль дөрвөн жил тутамд болж, УИХ-ын 76 гишүүн, нийслэл, аймаг, сум, дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгчдийг сонгодог. Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн жил тутамд зохион байгуулж, нийт ард түмний саналаар сонгодог.

Хэвлэлийн хүрээлэнгийн “Монголын хэвлэл мэдээлэл – Өнөөдөр” 2020 тайланд дурьдсанаар нийт 502 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаагаа явуулж, тэдгээрт 4700 орчим хүн ажиллаж буйн тал нь сэтгүүлч, редактор зэрэг сэтгүүл зүйн хэм хэмжээний дагуу ажиллах үүрэг бүхий ажилтан байна.

Олон нийтийн сүлжээ идэвхтэй тархаж, хүн бүхэн мэдээллийг хүссэн хэлбэрээрээ шуурхай түгээж чаддаг болсон энэ үед сонгуулийн агуулгыг өндөр ёс зүйтэйгээр сурвалжлан хүргэж, мэргэжлийн ялгарал бий болгох нь хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсадын үүрэг болоод байна. Гэвч 500 гаруй мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээ бүхэлдээ “сонгууль” гэсэн ганцхан үйл явдалд тулгуурлан ажиллаж байгаа нөхцөлд редакцууд ёс зүйн хэм хэмжээгээ сахихын зэрэгцээ хүлээн авагчдынхаа сонирхлыг татахуйц, сонгогчдод боловсрол олгох, өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулах нь ихээхэн ур чадвар шаардах боллоо.

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, чөлөөт шүүмжлэл өрнүүлэх зэрэг хүний үндсэн буюу жам ёсны эрхээ хэрэгжүүлэх боломжтой нөхцөлд ард иргэд улс төрийн сонголтоо бүрэн дүүрэн, итгэл төгс хийж чадна. Дараах зүйлсийг ардчилсан сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн байгууллагууд онцгой анхаардаг:

- Иргэдийг бодитой, баримттай, олон талын эх сурвалжаар баталгаажсан, тэнцвэртэй мэдээллээр хангах

- Сонгуулийн үед сонгогчдын боловсролын асуудалд анхаарал тавьж, тусгай булан, эфирийн цаг гарган ажиллах
- Иргэдийн мэдэх эрхийг бүх төрлөөр хангахыг эрмэлзэх, иргэд сонгогчдын дуу хоолойг олон нийтэд хүргэх боломжоор хангах
- Намууд, нэр дэвшигчдэд ялгаварлалгүйгээр, тэнцвэртэй хандах
- Хэвлэл мэдээллийн байгууллага, редакц, сэтгүүлч мэргэжлийн зарчмаа өндөрт баримталж, ёс зүйтэй, хүнлэг энэрэнгүй байдлаар ажилдаа хандах

Мэргэжлийн сэтгүүлчдийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрддөг “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” нь улс орны өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн сонгуулийн сурталчилгааны үед энгийн үеийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ. Харин сэтгүүл зүйн нөлөө, үр дагавар нь энгийн үеэс хэд дахин өсөн нэмэгдэж, олон нийтийн үнэлгээг давхар авдаг. Иймд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийн үед “хоточ банхар”-ын үүргээ нэр төртэй биелүүлэхийн сацуу мэргэжлийн сэтгүүлчдийн нэр хүндийн хамгаалалт болсон мэргэжлийн ёс зүйн зарчмаа чанд сахин мөрдөж ажиллах нь чухал.

Сонгуулийн үеэр ёс зүйн зарчмын олон заалт зөрчигддөг бөгөөд үүнд, сэтгүүлч мэдээллээ бусдаас шуурхай хүргэхийн тулд нягтлалгүйгээр санамсаргүй алдаа гаргах, эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягтлахгүй байх, буруутгагдсан этгээдэд тайлбар өгөх боломж олгохгүй байх, хэвшмэл ойлголтуудыг түгээх, хүний эрхийг зөрчих, төлбөрт нийтлэл нэвтрүүлгийг редакцын бүтээлээс ялгахгүй байх зэрэг алдааг гаргадаг. Сонгуулийг сурвалжлах явцдаа хэвлэл мэдээллийн байгууллага, редакц, сэтгүүлчид алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс энэхүү “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах нь” зөвлөмжийг хүргэж байна.

Энэхүү зөвлөмжийг бичихдээ Хэвлэл мэдээллийн зөвлөлийн “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын заалтуудад үндэслэн, сэтгүүл зүйн байгууллага, эзэд, редакц-сэтгүүлч-улстөрийн нам, нэр дэвшигчид- иргэд, сонгогчид- хууль эрх зүй, журам гэсэн талуудыг хамрууллаа.

Энэхүү зөвлөмж нь цаг үе, нөхцөл байдалтай уялдан сайжран өөрчлөгдөж байх юм.

## Бэлтгэл ажиллагаа:



Хугацааны хувьд УИХ-ын сонгуулийг тухайн жилийн зургаадугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр, Орон нутгийн сонгууль аравдугаар сарын эхний хагаст, Ерөнхийлөгчийн сонгуулийг сонгуулийн жилийн тавдугаар сарын сүүлийн хагасын аль нэг долоо хоногийн ням гарагт зохион байгуулдаг. Сонгуулийн өмнөх жилийн сүүлийн улирлаас редакцууд сонгуулийн жилийн контентын төлөвлөгөөг гаргах нь бэлтгэл ажиллагаа сайтай, алдаа багатай ажиллах үндэс болдог.

Төлөвлөлтөө гаргахдаа дараах зүйлсийг анхаарна.

- Контент, түүний шинэлэг байдал
- Хүний нөөц
- Хамтын ажиллагаа
- Сургалт
- Шаардлагатай журмууд
- Төсөв
- Редакцын тэмдэглэл

**Контент, түүний шинэлэг байдал:** Төлөвлөгөө гаргахдаа нийт контентын агууламж, цаг, талбайдаа анализ хийж тэдгээрт сонгуулийн контентыг ямар хуваарьтайгаар нэмж оруулахаа тооцоолсноор энгийн болон сонгуулийн контентын хувиа зохих шалгуураар бий болгоно. Аливаа редакц өдөр тутамд нийтлэн, нэвтрүүлж буй мэдээ мэдээллийнхээ төрлийг бүртгэлжүүлснээр нийт агуулгад эзэлж буй төрлүүдийн эзлэх хувийг тодорхойлж болдог. Жишээ нь, мэдээллийн сайтууд мэдээгээ программдаа татан оруулахдаа “Мэдээний категори” хэсэгт тэмдэглэх боломжтой. Ингээд долоо хоног тутамд мэдээний категориудаас аль нь дийлэнх хувийг эзэлж, аль нь маш бага хэмжээгээр орж буйг тодорхойлсны үндсэн дээр дараагийн сард мэдээнийхээ төрлийг нэмэгдүүлнэ. Жишээ нь, тухайн сард нийт 500 мэдээлэл бүртгэгдсэний 40 хувь нь зөвхөн “Улстөр” гэсэн төрөлд бүртгэгдэж, “Боловсрол” төрөл мэдээллийн 5 хувийг эзэлж байвал “Боловсрол” төрөлд түлхүү анхаарч эзлэх хувийг 10 болгохын төлөө хичээн ажиллах гэсэн редакцын бодлогыг удирдлагууд боловсруулна гэсэн үг. Үүнтэй адилаар, өдөр тутмын сонин болон телевизийн өдөр тутмын мэдээллийн төрлийг бүртгэлжүүлэн хөтлөх нь агуулгаа захиран удирдах боломжийг редакцад олгох давуу талтай.

Сонгуулийн контент нь дотроо сонгогчдын боловсролд зориулсан, нам, нэр дэвшигчдийн сурталчилгаа, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх индэр, Сонгуулийн Ерөнхий хорооны мэдээлэл, хэвлэлийн хурал, сонгуультай холбоотой үйл явдлын мэдээллүүд зэрэгт хуваагдана. Дээр өгүүлснээр мэдээллийн төрлөө бүртгэлжүүлж хэвшвэл сонгуулийн үеэр агуулгынхаа хэдэн хувьд боловсролд зарцуулах, хэдэн хувьд нэр дэвшигчдийн сурталчилгаа байхыг төлөвлөж чадахын зэрэгцээ хүлээн авагчдаа нэг төрлийн мэдээллээр уйдааж, залхаахгүй.

Сонгуулийн үеэр бүх л хэвлэл мэдээллийн хэрэгслээр ерөнхийдөө ижил төрлийн контентууд цацагдана гэдгийг тооцоолж, өөрийн редакцын ялгарах давуу тал нь юу байх вэ гэдгээ тодорхойлно. Хэвлэлийн мэдээг ч сэтгүүл зүйн бүтээл болгож, бүтээлч байдлаар бусдаас ялгаатай мэдээлж чадвал танай байгууллага аажимдаа хүлээн авагчдынхаа итгэлийг олох нь дамжиггүй. Сонгуулийн сурталчилгааг намууд болон нэр дэвшигчдийн пиар багийнхан нэг форматаар бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ижил агуулгаар цацах нь элбэг. Тиймээс сонгуулийн сурталчилгаа нэг форматаар цацагдах бол бусад мэдээлэл болох сонгогчдын боловсролд зориулсан агуулга болон шүүмжлэлт сэтгүүл зүйн бүтээлүүдээ бүтээлчээр хийхийн тулд урьдаас сайтар төлөвлөж, бэлтгэсэн байх нь зүйтэй.

Эдгээр мэдээллийг хэвлэмэл /сонин, сайтууд/ мэдээллийн хэрэгслүүд текст, график, зураг /фото, зурмал, газрын зураг, хөдөлгөөнт зураг г.м/, видео, инфографик гээд олон төрлөөр бэлтгэн нийтлэх боломжтой. Телевизийн хувьд ярилцлага, текст, видео график гэх мэт төрлүүд багтана.

**Хүний нөөц:** Сонгуулийн үеэр үйл явдлууд давхцах нь элбэг. Түүнчлэн Сонгуулийн тухай хууль, сонгуулийн үеэр гарсан зарим журмын биелэлтийг хангахын тулд мэдээллийг хянан тохиолдуулах хүн ажиллуулах, тоог нь нэмэх шаардлага тулгарч мэднэ. Мөн гэрээт сэтгүүлч, зурагчин, зураглаачийн тоог нэмэх шаардлага гарах уу, эс бөгөөс аль нэгэн агентлагтай хамтран ажиллах уу гэдгийг урьдаас тооцоолон төлөвлөнө.

**Хамтын ажиллагаа:** Нийгэмд ялгарал бүхий олон өөр бүлгүүд бий болсон, хүний эрхийн мэдлэг улам бүр нарийссан зэргээр хүлээн авагчдын мэдлэг боловсрол өндөрсөх тусам хэвлэл мэдээллийн байгууллагуудын агуулгын чанар, тэгш байдлыг хангах, хүний эрхийг дээдлэх зэрэгт онцгой анхаарсан байх нь зайлшгүй болоод байна.



Эдгээрийг ханган ажиллахын тулд редакц дангаараа ажиллах нь учир дутагдалтай болдог тул мэргэжлийн бүлгүүдтэй хамтын ажиллагааг бий болгох нь агуулгын чанарт эерэгээр нөлөөлнө. Сонгуулийн үеэр хамтран ажиллах байгууллагуудыг тодорхойлж, мэргэжилтнүүдтэй холбогдоно. Жишээ нь, “Сонгогчдын боловсрол төв”-ийн хэн гэдэг мэргэжилтэнтэй байнгын холбоотой байх вэ, ямар төрлийн агуулгыг энэ байгууллагаас авч болох вэ гэдгээ тодорхойлно. Мөн хуулийн ямар байгууллагатай холбоотой байж болох /эсвэл хуульчтай/ вэ, түүнтэй сонгуулийн үеэр ямар асуудлаар холбогдож болох вэ гэх мэт.

Зарим редакц зөвлөхийн тоог нэмж, хөндлөнгөөс агуулгаа хянуулсны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

**Сургалт:** Сургалт нь агуулгын чанарыг сайжруулах, сэтгүүлчдийн мэдлэгийн хүрээг нэмэгдүүлж, асуудлыг олон талаас харах чадварыг суулгадаг сайн талтай. Сонгуулийн тухай хуулийг судалж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаатай хэсэгт нь алдаа гаргаж болзошгүй заалтуудыг анхааралдаа аван, редакцаараа хэлэлцэнэ. Шаардлагатай тохиолдолд хуульчийн туслалцаа, нэг удаагийн сургалт зэргийг авах боломжтой.

Сэтгүүлчдийнхээ нөөц бололцоог сайтар мэдэр. Тэдний хэд нь сонгуулийн үеэр ажиллаж байсан туршлагатай, хэд нь огт туршлагагүй вэ? Туршлагатай сэтгүүлчид нь дотоод сургалт хийж, анхаарах зүйлсийг бусдадаа хуваалцах боломжийг бий болго. Бусад мэргэжлийн байгууллагуудаас ч шаардлагатай сургалт авах нь нээлттэй.

**Шаардлагатай журмууд:** Сонгуулийн үеэр ажиллахдаа мөрдөх журмыг боловсруулж, сэтгүүлчдэдээ танилцуулан, дагаж мөрдөхийг илэрхийлсэн баримт бичигт гарын үсэг зуруулснаар харилцан хариуцлагатай ажиллах боломж бүрдэнэ. Энэ журамд танай нүүр царай болсон хөтөлгөч, сэтгүүлчид болон бусад ажилтны сошиалд баримтлах бодлого, ёс зүйн зарчмуудыг багтааж болно. Жишээ нь, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан редактор, сурвалжлагч нарт зориулсан “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого” зөвлөмжид сэтгүүлч улс төрийн үзэл баримтлалынхаа талаар сошиал хуудсандаа оруулах шаардлагагүй талаар дурьдсан нь бий. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс боловсруулсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”, “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого” гэсэн баримт бичгүүдийг баримтлан ажиллах боломжтой.

Сонгуулийн үеэр онцгой нөхцөл байдал үүсвэл сэтгүүлчдийнхээ аюулгүй байдлыг хангахын тулд ямар арга хэмжээ авч болохыг урьдчилан тооцоолно. Ингээд аюулгүй байдлын журмыг редаксаараа ярилцан, өмнөх сонгуулиудад гарч байсан туршлагауддаа үндэслэн, гадны хэвлэл мэдээллийн байгууллагуудын журмыг орчуулан шаардлагатайг нь буулган боловсруулаарай. Жишээ нь, эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд тухайн нөхцөлд ажиллаж байгаа сурвалжилгын багаа буцаан татах уу, эсвэл сурвалжилгыг үргэлжлүүлэх үү? Үргэлжлүүлэх бол “яагаад” гэдгийг бодож, төлөвлөсөн байна. Ажилтнууд чинь эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдахаар хэмжээний хохирол амсахаар бол яах вэ? Ажилтнууд чинь үймээн самуунтай үеэр аюулгүй байдлаа ханган ажиллах хэмжээний мэдлэгтэй юу? Редаксаас тийм хэмжээний мэдлэг олгох аливаа сургалтанд хамруулсан уу гэх мэт. Эдгээрийг дүгнэн хэлэлцсэний эцэст журмаа боловсруулж, ажилтнуудаа ажилд гарахын өмнө заавал журмыг уншиж танилцуулна. Ажилд гарах бүрт!

**Төсөв:** Шинэлэг контент бүтээх, томилолтоор ажиллах, түр болон гэрээт ажилтан нэмэх эсэхийг тооцоолсноор шаардлагатай төсвийн хэмжээг гаргана. Мөн техник хэрэгсэл нэмэлтээр авах шаардлагатай бол түүний төсвийг тооцоолно. Жишээлбэл, Ерөнхийлөгчийн сонгууль орон даяар болдог ч алслагдмал аймаг, сумдад сонгуулийн сурталчилгаа, үйл ажиллагаа хэрхэн явагдаж, иргэд ямар бодолтой байгаа талаарх сурвалжилгыг олон үзэгчтэй арилжааны телевизүүд төдийлөн хийдэггүй. Тиймээс бусдаас ялгаатай контент бүтээхийн тулд сэтгүүлч, зураглаач, жолооч гурвыг томилолтоор явуулахаар төлөвлөж болох билээ.

**Редакцын тэмдэглэл:** Сонгуулийн үеийн тэмдэглэлийг редакц үргэлж хөтөлж байх нь дараагийн сонгуульд алдаагүй ажиллах сургамжит түүхийг бий болгоно. Сэтгүүлчид юун дээр алдсан, ямар контентын агуулганд анхаарах ёстой байсан, уншигчид, үзэгчдийн ямар хүслийг гүйцэлдүүлж чадаагүй, ямар дүрэм журам дутуу байсан зэргээ тухай бүрт нь тэмдэглэн үлдээх нь зүйтэй. Сонгууль дууссаны дараа зарим зүйл мартагдах боломжтой тул эхнээс нь тэмдэглэх үйл ажиллагааг хөтлөн явуулахаар төлөвлөнө.

## 2. АНХААРАХ ЗҮЙЛС:



Сонгуулийг сурвалжлахдаа ёс зүйн алдаа гаргах нь нийгэмд ихээхэн хор уршиг тарих эрсдэлтэй бөгөөд зарим тохиолдолд зөрчилдөөн мөргөлдөөний эх үүсвэр болох ч магадлалтай. Тиймээс редакцууд шуурхай байдлаараа уралдах бус баримтад тулгуурласан, тэнцвэртэй, бодитой мэдээлэлд анхаарч ажиллах нь чухал.

Хэвлэл мэдээллийн байгууллага нь зөвхөн нам, нэр дэвшигчдээс өгсөн материалыг нийтлэн, нэвтрүүлээд зогсохгүй сонгуулийн кампанит ажлын явц, мөрийн хөтөлбөр зэрэгт дүн шинжилгээ хийж, шүүмжлэлт байдлаар хандсан контент бүтээх нь дараа дараагийн сонгуулиудад намуудын мөрийн хөтөлбөр илүү сайжрах, сонгуулийн үйл явц өндөр түвшинд явагдах нэг үндэс болдог.

Сонгуулийн талаарх сэтгүүл зүйн бүтээл жил ирэх бүр нэмэгдсээр байгаа ч, үйл явдлын мэдээ голлох байрыг эзэлж буй тул задлан шинжилсэн даацтай бүтээлийн тоог нэмэх, чанарыг сайжруулах шаардлагатай. Хэвлэл мэдээллийн байгууллагуудаас сонины зай талбайд сонгуулийн талаарх сэтгүүл зүйн бүтээлийн эзлэх хувийг дараах байдлаар гаргажээ:

2008 онд 1.7%

2009 онд 6%

2012 онд 8.7%

2016 онд 22%

<sup>14</sup>“Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг” Хэвлэлийн хүрээлэн, 2016 он

## Хэвлэл мэдээллийн байгууллагын эздэд:



Хэвлэл мэдээллийн эзэмшлийн хэд хэдэн төрөл байдгаас манай улсад Олон нийтийн эзэмшлийн /Олон нийтийн радио, телевиз буюу Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газраас томилсон Үндэсний зөвлөлийн 15 гишүүнтэй, улсын төсвөөс дэмжлэг авдаг/, хувийн эзэмшлийн буюу ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг болон хүйн хэвлэл мэдээлэл гэсэн төрлүүд байна.

Сэтгүүл зүй гэдэг бусад бизнесээс өөр. Сэтгүүл зүйгээр дамжуулан иргэдийн үзэл бодол, байр суурь, хандлагад нөлөөлж байдаг. Сэтгүүл зүй хараат бус байж чадах эсэхээс ардчиллын багана хэр бат бөх байх нь шалтгаална. Тиймээс энэ төрлийн бизнесийг эрхлэгчид болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг сэтгүүлч, ажилтнуудын сэтгэл зүрх, ёс зүй, мэргэжлийн чадвар зэрэг олон зүйл дээр сэтгүүл зүй тогтдог.

Сэтгүүл зүйн үйл ажиллагаа нь нэг талаас уншигч, үзэгчдийнхээ итгэлийг хүлээснээр бизнесийн үйл ажиллагаандаа амжилт авчирдаг. Уншигч, үзэгчдийн итгэлийг олж авахын тулд сэтгүүл зүйн бүтээлүүд нь мэргэжлийн түвшинд, бодитой, олон эх сурвалжаар хангагдсан байдаг. Ийнхүү ажиллах боломжийг олгохын тулд хэвлэл мэдээллийн байгууллагын эздэд нь редакцын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх гэрээг редакциятайгаар байгуулдаг зарчим олон улсад нийтлэг бий.

Харамсалтай нь, эздийн оролцоо сонгуулийн үед ихэсдэг. Сонгуулийн үеэр редакцын бодлого, бүтээлийн агуулгад эзэд оролцох нь байгууллагын соёлд сөргөөр нөлөөлж, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулдаг. Сэтгүүлчдийн мэргэжлийн үнэлэмж, итгэл үнэмшил буурч, ажилдаа хандах хандлага сулардаг. Эздийн хэт их оролцоо, дарамт хэрхэн нөлөөлдгийг “Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторинг”-д дараах байдлаар тусгажээ.

“Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн дарамт: Бизнес, улс төрийн нягт холбоо нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчдэд дарамт болж ирдэг. Тухайн мэдээллийн хэрэгсэл улс төрийн, эсхүл санхүүгийн хараат байдалд байх тохиолдолд олон нийтийн гэхээс илүү эзэн, санхүүжүүлэгчийн ашиг сонирхолд үйлчилнэ. Энэ нь юу гэсэн үг гэвэл сэтгүүлчид мэргэжлийн үүрэг хариуцлагаа хараат бусаар хэрэгжүүлэх боломжгүй бол хэлэх үгээ хянаж эхлэх буюу өөрийн цензур газар авна. Нөгөө талаас сэтгүүлчид хэт их

ажлын ачаалалтай, хэт бага цалинтай учир мэргэжлийн үүрэг хариуцлагаа “төлбөртэй мэдээллээр” худалдах нь энгийн үзэгдэл болно”.<sup>2</sup>

Тиймээс эздийн зүгээс сонгуулийн үеэр нийтлэлийн бодлогод аль болох оролцохгүй байх, эздээр дамжуулан нийтлэл, нэвтрүүлэгт нөлөөлөх гэж оролдсон талуудад “Редакц нь тусдаа, бие даасан үйл ажиллагаа явуулдаг” гэдгийг ойлгуулах, редакцтайгаа “Зөвхөн бизнесийн ашиг тус хүртэнэ. Нийтлэлийн бодлогод оролцохгүй” гэх агуулга бүхий гэрээ байгуулахыг эрмэлзэх нь сэтгүүл зүйн цэвэр, урт хугацаанд ашиг олох бизнес эрхлэхэд тустай.

### Редакцын зүгээс анхаарах:



Редакцууд нам болон нэр дэвшигчтэй сонгуулийн сурталчилгааны гэрээг урьдаас бэлтгэн, байгуулдаг. Гэрээний дагуу редакцад ирж буй сонгуулийн сурталчилгаа /нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл гэх мэт/ нь ямар агуулгатай байгааг сайтар судалж, өөрийн бүтээл мэт нягтална. Сонгуулийн “хар пиар”-ыг нийтлэн, нэвтрүүлэхээс татгалзаж, тухайн нэр дэвшигч болон намаас гагцхүү мөрийн хөтөлбөр, зорилго зорилтоо сурталчлах шаардлагыг гэрээнд тусгана. Ингэснээр сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах сэтгүүл зүйн үүргээ биелүүлэх эхлэл болох юм. Хэдийгээр тухайн сурталчилгааны нэвтрүүлэг, нийтлэлийг танай редакц бүтээгээгүй ч, танай байгууллагын өөрийн талбарт гарч буй нийтлэл, нэвтрүүлгийн агуулгыг та бүхэн хариуцна. Уншигч, үзэгчдийн хувьд ч танай сувгаар нэвтэрч байгаа бүхэн нэгэн цул юм.

Сонгуулийн үеийн нийт сурталчилгааны цагийг шударгаар хуваарилна. Шударга гэдэг нь тэнцвэр барих, төвийг сахих, үл ялгаварлах зарчим бөгөөд эрх баригч, цөөнх, сөрөг хүчинд ялгаварлалгүйгээр хандахыг хэлж буй. “Глоб интернэшнл” төвөөс 2020 оны УИХ—ын сонгуулийн сурталчилгаанд телевизийн мониторинг хийж, олон нийтийн санхүүжилт ашигладаг, хамгийн хүртээмжтэй, орон даяар цацагддаг таван телевизийг хамруулахад 2016-2020 онд төрийн эрх барьсан МАН-д давуу байдлаар үйлчилсэн байна. Нийт 5 телевизийн дунджаар төвийг сахисан мэдээлэл давамгайлсан нь 56% байжээ.<sup>3</sup>

<sup>2</sup> “Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг” Хэвлэлийн Хүрээлэн, 2016 он

<sup>3</sup> Глоб интернэшнл төв: “2020 оны УИХ-ын сонгуулийн үеэрх телевизийн мониторинг”

Редакцтай гэрээтэй ажилладаг нийтлэлчдийн бүтээлд мөн энгийн үеэс илүү хяналттай хандана. Шаардлагатай гэж үзвэл сэтгүүлчидтэйгээ байгуулсан “Сонгуулийн үеэр мөрдөх журам”-ыг гэрээт нийтлэлч, идэвхтэн бичигч, сэтгүүлчидтэйгээ байгуулна.

Сонгуулийн үед редакторуудын хариуцлагыг өндөрсгөх, редакторгүй бол сонгуулийн үеэр ажиллуулах түр редактор ажиллуулах нь учирч болох эрсдэлээс хамгаална. Редакторууд бүтээлийн гарчиг, агуулгын зөрүүтэй байдлыг сайтар хянах нь зүйтэй. Гарчгаар хөтлөгдөн сошиалд шуугиан дэгдэх магадлалтайг анхаар. Гарчигт хөндөгдсөн хурц сэдэв нь агуулгадаа дурдагдаагүй, дурдагдсан ч баримтаар нотлогдоогүй бол мэргэжлийн томоохон алдаа болно. Түүнчлэн редактор нь дээр өгүүлсэн гэрээт сэтгүүлчид, нийтлэлчдийн материалыг хянах, нам, нэр дэвшигчдээс ирж буй сурталчилгааны материалын хуульд зохицсон эсэхийг хянах ажлуудыг давхар хийнэ.

УИХ-ын 2020 оны сонгуулиар телевизүүдэд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын “Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана” гэсэн 9 дүгээр зүйлийн зөрчил түлхүү ажиглагдсаныг мэргэжлийн байгууллагын мониторинг харуулсан. “Глоб интернэшнл” төвийн мониторингод (нэгдүгээр үе) далд сурталчилгаа явуулсан эсэхэд хяналт тавихад, арилжааны телевизүүдийн далд сурталчилгаа 8-25%-ийг эзэлж байжээ. Тиймээс сонгуулиар ёс зүйн зарчмын энэ заалтыг биелүүлж ажиллахыг сайтар анхаарууштай. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 9.1-т “Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана” хэмээн заасан байдаг.

Танай аль нэгэн сэтгүүлчийн аав ээж, ах дүү, найз нөхдөөс сонгуульд нэр дэвшиж байгаа бол түүнийг “ашиг сонирхлын зөрчилтэй” хэмээн үзэж, сонгуулиар ажиллуулахаас аль болох татгалзана. Сонгуулийн үеэр ч энгийн мэдээллүүд тасралтгүй гарч байдаг тул тэдгээр мэдээллийг хариуцуулан ажиллуулж болох юм.

### Сэтгүүлчдийн анхаарах зүйлс:



Аливаа мэдээллийг олон нийтэд хүргэхдээ өөрийн үзэл бодлоо шигтгэх, бусдад үзэл бодлоо тулгах зэрэг нь мэргэжлийн ноцтой алдаа болно.

Нам, нэр дэвшигчдээс өгч буй статистик тоо, баримт, хэвлэлийн хурал зэрэг нь нэгл түвшний эх сурвалж бөгөөд баримтыг бусад эх сурвалжуудаар заавал нягталж, баяжуул.

Сонгуулийг сурвалжлах үйл явцад эрх баригчид болон санал авах байруудад ажиллаж байгаа ажилтнууд хуулийн мэдлэггүйн улмаас, эсвэл зориудаар эрх бүхий сэтгүүлчийг санал авах байрнаас хөөж гаргах зэрэг хууль бус шаардлагыг тавих тохиолдол гардаг. Энэ мэт тохиолдлуудад сэтгүүлч хуулийн дагуу өөрийн эрх үүргээ сайтар мэддэг байх, зохих шаардлагаа тавьж чаддаг байх нь чухал. Үүний тулд Сонгуулийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль зэрэг холбогдох хуулиудаас өөрт хэрэгтэй заалтуудыг уншиж, мэдсэн байвал зохино.

Сэтгүүлчид бүтээлээрээ дамжуулан, мөн өөрийн сошиал хуудсаараа хэн нэгэн нэр дэвшигч, аль нэг намыг дэмжихгүй, мөн дэмжих, эс дэмжихийг бусдад уриалахгүй байх нь ёс зүйд нийцнэ. Тухайн сэтгүүлчийн байр суурийг редакцын байр суурьтай андуурах нь нийтлэг тул үзэгч, уншигчдаа төөрөгдүүлэх шаардлагагүй. Таны дэмжсэн улстөрч авлигын хэрэгт орооцолдохгүй гэх баталгаа үгүй бөгөөд тийм зүйл боллоо гэхэд дэмжин, уриалж байсан сэтгүүлчид итгэх хүлээн авагчдын итгэл суларна. Мөн таны дэмжсэн нам сонгуульд ялалт байгуулвал эрх баригчдын үйл ажиллагаатай холбоотой сэтгүүл зүйн шүүмжлэлт бүтээлийг олон нийтэд хүргэх нь итгэл үнэмшилгүй болгох сөрөг талтай.

Сэтгүүлч өөрийн бүтээлдээ төдийгүй сошиал хуудсуудаараа дамжуулан үзэн ядсан үг хэллэг болон шашин шүтлэг, нийгмийн гарал үүсэл, бэлгийн чиг баримжаа, үзэл бодлоор ялгаварлан гадуурхсан үг хэллэг хэрэглэхгүй байхад онцгой анхаарна.

Сэтгүүлч намууд болон нэр дэвшигчээс ямар нэгэн хэлбэрээр бэлэг, дурсгал, урамшуулал, үнэт зүйл хүлээн авахгүй. Мөн тэдгээрийн хүлээн авалт, амралт зугаалгад хамрагдахгүй байх нь зүйтэй юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд болон редакц, улс төрийн хүчин, нэр дэвшигчид хууль бус зүйл хийхийг сэтгүүлчээс шаардах эрхгүй бөгөөд, сэтгүүлч тийм шаардлагыг эсэргүүцэх эрхтэй.

## Худал мэдээлэл, доромжлол, гүтгэлгийг түгээхгүй байх

Сонгуулийн үед хамгийн түгээмэл ажиглагддаг хуурамч мэдээлэл, гүтгэлэг, доромжлол нь мэргэжлийнхний хувьд хэзээ ч хүлээн зөвшөөрч болохгүй үзэгдэл юм. Тиймээс сэтгүүлч, сурвалжлагчид аливаа мэдээ, мэдээллийг түгээхдээ туйлын хянуур байж, санамсаргүй алдаа гаргахаас сэргийлэн, олон эх сурвалжаар баталгаажуулсны дараа хэвлэл мэдээллийн хэрэгслээрээ түгээх нь зүйтэй.

2012, 2016 оны сонгуулийн сурталчилгааны үеэр хэвлэл мэдээллийн байгууллагуудад хийсэн “Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг”-д:

“Сонгуультай холбоотой сэтгүүлзүйн бүтээлийн зөвхөн 8 хувь нь хоёр болон түүнээс дээш түвшний, өөр өөр ашиг сонирхол бүхий этгээдийг эх сурвалж болгон ашигласан байна. Сэтгүүл зүйн дийлэнх мэдээлэл нэг эх сурвалжид тулгуурлаж буйгаас гадна зохиогчгүй, хувийн үзэл бодлыг баримтат мэдээлэлд оруулсан байх алдаа дутагдал түгээмэл байв”<sup>4</sup> хэмээн дурьдсан байдаг.

Сонгуулийн үед мэдээллийн хурдаас илүүтэй бодитой, баримттай, тэнцвэртэй мэдээлэл хамгийн чухал.

Сонгуулийн үр дүнг мэдээлэх үед сэтгүүлчид бусдаас түрүүлэх, шуурхай байхад хэт автан худал мэдээлэл түгээх, олон нийтийг төөрөгдөлд оруулах эрсдэл өндөр болдог. Учир нь энэ үед олон хэрэглэгч хамгийн түрүүнд гарах мэдээллийг “амьсгаа даран” хүлээдэг тул хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сэтгүүлчид туйлын сонор сэрэмжтэй байж, аливаа мэдээллийг албаны мэдээллээр баталгаажуулж цацах нь зүйтэй юм.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын нэгдүгээрт дараах зүйлсийг тусгасан байдаг<sup>5</sup>

1.1 Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ.

<sup>4</sup>“Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг” Хэвлэлийн Хүрээлэн, 2016 он

<sup>5</sup>Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим <http://www.mediacouncil.mn/p/7>



## 1.2 Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ.

Ёс зүйн зарчмын нэгдүгээрт заасны утгыг сануулах мэт Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирсэн гомдлын дийлэнх хувийг эзэлдэг, сэтгүүлчдийн алдааны нэгдүгээрт жагсдаг зүйлс бол дээрх агуулга юм. Тиймээс сэтгүүлчид та бүхэн сонгуулийн үеэр ёс зүйн зарчмаа баримтлан ажиллах нь чухал.

Хуурамч мэдээллийг түгээх нэг эх үүсвэр нь социал медиа болдог. Тиймээс энэ үед социал медиаг мэдээллийн эх сурвалжаа болгохгүй байх, эх сурвалж болгох тохиолдолд заавал бусад эх сурвалжаар баталгаажуулах, постын эзнээс зөвшөөрөл болон тодруулга авах зэрэгт анхаарна. Зөвхөн текст агуулга төдийгүй видео эвлүүлэг, гэрэл зургууд ч хуурамч байж болдог гэдгийг сануулъя.

Дараах ялгааг сэтгүүлчид мэдсэн байвал зохино. Үүнд:

**Худал мэдээлэл /disinformation/-** Хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага, улс оронд хохирол учруулах зорилгоор санаатайгаар бий болгосон худал мэдээлэл. Ялангуяа засгийн газар, улс төрийн намаас өрсөлдөгч хүчин, хэвлэл мэдээллийг төөрөгдүүлэх зорилготой гаргасан суртал ухуулга.

**Буруу ташаа мэдээлэл /misinformation/-** Хохирол учруулах санаа, зорилго агуулаагүй худал мэдээлэл

**Хуурамч мэдээлэл /mal information/-** Бодит байдалд тулгуурласан бөгөөд хувь хүн, байгууллага, улс оронд хохирол учруулах зорилгоор ашигладаг мэдээлэл.

Сонгуулийн үеэр шууд мэдээнээс аль болох зайлсхийх нь дээр. Хэвлэлийн хурал, аливаа үйл явцыг шууд дамжуулах нь худал, гүтгэлэгт мэдээлэл болон эфирээр цацахад тохиромжгүй дүрсийг хяналтгүйгээр олон нийтэд тараах эрсдэлийг бий болгодог. Тиймээс аль болох мэдээллийг нягтлах цаг гаргахын тулд урьдчилан бэлтгэх боломжийг бий болгохыг хичээх нь зүйтэй.

Хэвлэлийн хурлыг шууд дамжуулах бус сэтгүүлч шаардлагатай мэдээллийг авч, бэлтгэсний дараа нийтэлж, нэвтрүүлэх, зарим тохиолдолд бусад эх сурвалжуудаар баталгаажуулан эх сурвалжийн төрлүүдийг ашиглах зэргээр ажиллана.

## Буруутгагдсан этгээдэд тайлбар өгөх боломж олгох

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.8-д “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно”, 10 дугаар зүйлд “Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ” хэмээн заасан байдаг. Сонгуулиудаар аль нэгэн нам, нэр дэвшигчийн хэн нэгийг буруутгасан мэдээллийг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуусахаас өмнөхөн “амжуулах” нь бий. Ингэснээр буруутгагдсан этгээдэд тайлбар өгөх боломж олдохгүй байх, олдсон ч “үнэ цэнтэй” хугацаа нь хэдийнээ өнгөрсөн байх тохиолдол олон.

Ингэснээр сэтгүүл зүйн хүнлэг, энэрэнгүй байх зарчмыг үгүйсгэж буй хэлбэр юм.

## Залруулга хийх, уучлалт хүсэх

Мэргэжлийн, хариуцлагатай сэтгүүл зүйн нэг ялгарал нь хийсэн алдаандаа залруулга гаргах чадвар юм.

Залруулга нь хэлбэр төдий биш байх нь хариуцлагаа үүрч буйг илэрхийлэх нэг арга болно. Өөрөөр хэлбэл, алдаа гаргасан нийтлэл, нэвтрүүлгийн зай талбай, нэвтрүүлгийн цагтай хэмжээ, хугацааны хувьд дөхүү байхыг анхаарна.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.9-д “Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна” хэмээн заасан. Дээр өгүүлсэнчлэн, сонгуулийн сурталчилгааны хугацаа богино байдаг тул алдаа гаргаж, бусдын нэр хүндэд халдсан тохиолдолд Ёс зүйн зарчимд заасанчлан алдаагаа хурдан ухамсарлаж, залруулгаа нэн даруй гаргах нь зүйд нийцнэ.

Сонгуулийн үеэр хүний нэр төрд халдах, гүтгэх талаар заасан Эрүүгийн хууль хэрэгжсээр байх болно.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл “Худал мэдээлэл тараах”<sup>6</sup>

Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин

<sup>6</sup> <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

### **Төлбөртэй мэдээлэл, үзэл бодол, байр суурийг редакцын бүтээлээс ялгаж зааглах**

Редакцын бэлтгэсэн мэргэжлийн контентын агуулгаас үзэл суртал шингэсэн мэдээллийг тодорхой тэмдэглэн зааглаж, хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүй байх нь сэтгүүл зүйн нэг зарчим юм. Энэ нь нэг талаар иргэдийн мэдэх эрхийг хангах, нөгөөтээгүүр тухайн редакцын ил тод нээлттэй байдлын нэг хэмжүүр болно. Далд сурталчилгаанаас зайлсхийж, ёс зүй, үнэт зүйлээ нандигнан үлдэх нь энэ цаг үед ажиллаж буй хэвлэл мэдээллийн салбарын нийт ажилтны эрхэм үүрэг мөн.

Далд сурталчилгаа гэдэг нь: Сэтгүүл зүйн бичлэгийн хэлбэр, төрөл зүйлээр бэлтгэсэн боловч редакцын бүтээлээс ялгасан тэмдэглэгээгүй, олон нийтийн анхаарлыг татах зорилгоор пиар болон реклам сурталчилгааны арга техникийг ашигласан, тодорхой улс төрчийг илт дэмжсэн, сонгуульд өрсөлдөгч нэр дэвшигч эсвэл намын нэр хүндэд шууд халдсан бүтээлүүдийг хэлнэ.

“Төлбөртэй мэдээлэл” гэдэг нь сонгуулийн сурталчилгаа хийхээр гэрээ байгуулан ажиллаж буй нам, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг сурталчлан таниулсан мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг, нийтлэлийг хэлнэ.

“Үзэл бодол” гэдэг нь аливаа асуудлын талаар хэн нэгэн хүний бичсэн, нэг талын байр суурь, үзэл бодол бүрэн шингэсэн агуулга юм. Энэ агуулга нь сэтгүүл зүйн баримт түшиглэсэн бүтээлд тооцогдохгүй. Гэсэн хэдий ч “Үзэл бодол” нь бусдын нэр хүндэд халдах, гүтгэн доромжлох зэрэг хууль бус агуулгыг багтаахгүй.

Мөн сонгуулийн үеэр уншигчид, идэвхтэн бичигчдээс илгээсэн үзэл бодол, байр суурийн шинжтэй материалуудыг нийтлэхээр бол “Үзэл бодол”, “Байр суурь” зэргээр тусгайлан тэмдэглэж олон нийтэд түгээхийг эрмэлзэнэ. Энэ нь мэдээллийн хэт их урсгал дунд буй иргэдэд сэтгүүл зүйн бүтээлийн зааг ялгааг таньж мэдэх боломжийг олгох юм.

Сонгуулийн сурталчилгааны материалыг нийтэлж, нэвтрүүлэхдээ “Төлбөртэй сурталчилгаа” хэмээн тэмдэглэнэ. Энэ нь редакцын бүтээл, байр суурь тухайн бүтээлд агуулагдаагүй болохыг илтгэнэ.

Сонгуулийн үеэр судалгааны олон байгууллага ажиллаж, сэтгүүл зүйн бүтээлүүдэд дүн шинжилгээ хийн, эргэн мэдээлж ажилладгийг дашрамд сануулах нь зүйтэй.

### 3. ИРГЭНИЙ МЭДЭХ ЭРХ БА СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛ



Мэдээлэлтэй иргэд сонголтоо харьцангуй зөв хийдэг.

Нэр дэвшигчид болон намуудын мөрийн хөтөлбөрийн талаар мэдээлэл авах нь иргэний мэдэх эрх юм. Энэхүү мэдэх эрхийг хангахын тулд хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийн үеэр тэнцвэртэй, бодитой мэдээллээр иргэдийг хангана.

Иргэний мэдэх эрхэд: Мэдээлэл хайх, олж авах, хүлээн авах, түгээх үйл явц багтана. Иргэн хүн хуулиар хориглоогүй бүх мэдээллийг хүлээн авах эрхтэй. Мэдээллийг хүлээн авахдаа мэдээлэл авах хэлбэр, сувгаа сонгох, албан ёсны эх сурвалжийг мэдэх эрхтэй.

Нөгөө талаар, мөрийн хөтөлбөр болон сонгуулийн сурталчилгаанаас гадна сонгогчдод боловсрол олгох агуулга бүтээх нь туйлын чухал. Энэ нь ардчилсан нийгмийг бүтээж буй манай улсын хувьд сонгуульд иргэдийн зүгээс хяналт тавих, мэдээлэлд үндэслэн өөрийн дүн шинжилгээг хийж саналаа өгөх зэрэг боломжуудаар хангадаг.

Сонгуулийн үеэр редаксаас гаргах нийт бүтээлээ цэгнэсний эцэст сонгогчийн боловсролд хандсан контентын хувийг зохистой хэмжээгээр тогтоох, боломжтой бол тусгайлан булан гаргаж, эфирийн цагийг зориулахыг хичээн ажиллана. Сонгогчийн боловсролд зориулсан мэдээ мэдээлэл нь цаг үеийн мэдээлэл биш тул түүнийг урьдаас бэлтгэн, нийтлэн нэвтрүүлэх хугацааг зохицуулах боломжтой. Тиймээс энэ төрлийн мэдээллийг уншигч, үзэгчдийн сонирхлыг татахуйц байдлаар зурган болон

видео хэлбэрээр, мөн инфографик, зурган өгүүлэмж /комик/ зэрэг олон төрлөөр бэлтгээрэй.

Сонгогчийн боловсролын мэдээлэл гэдэгт хэзээ, хаана, хэрхэн сонгууль өгөх, сонгуульд оролцохын ач холбогдол, сонгуульд оролцож буй нам, нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл, сонгогчийн зүгээс тэдэнд ямар шаардлага тавих нь зүйд нийцэх, сонгуулийн зөрчлийн талаарх мэдээллийг хэрхэн мэдээлэх зэрэг орно.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль нь 2019 оны арванхоёрдугаар сарын 20-ны өдөр олон нийтэд хүрсэн. Өмнөх хуулиас нэлээн хэдэн зүйлээр ялгаатай, цар тахлын үеийн зохион байгуулалтад орсноос иргэд, намуудын штабынханд анхаарах зүйл олон болсон тул хэвлэл мэдээллийн байгууллагууд зохих мэдээллийг хүргэж ажиллана.

Орон нутгийн сонгууль нь иргэдийн өдөр тутмын амьдралд хамгийн ойр шийдвэрүүдийг гаргадаг, чухал нөлөөтэй сонгууль боловч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд УИХ-ын сонгууль шиг анхаарал хандуулдаггүй. Тиймээс иргэдийн хувьд мэдээлэл багатайгаар сонгуульд оролцож саналаа өгөх, зарим нь огт өгөхгүй байх хандлагатай бөгөөд 2004-2016 оны нийт дөрвөн удаагийн орон нутгийн сонгуулийн ирц хүрээгүй байдаг. Орон нутгийн сонгууль буюу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны нэгдүгээр сарын 30-ны өдөр хэлэлцэн баталсан. Нэлээд өөрчлөлт орсон энэхүү хуулийн заалтыг таниулах, сонгогчдод орон нутгийн сонгуулийн нөлөөллийг мэдүүлэх, нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, бодлогыг тэгш боломж олгон нийтэлж, нэвтрүүлэх нь зүйтэй.

## 4. ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



### Жендэрийн тэгш байдал

2016 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 25 хувь нь эмэгтэй нэр дэвшигчид байв. Гэвч сонгуулийн сурталчилгааны үеийн нийт контентын 14 хувь нь эмэгтэй нэр дэвшигчдийн талаар дурьдсан байжээ.<sup>7</sup>

Харин 2020 оны УИХ-ын сонгуульд 606 хүн нэр дэвшсэний 151 нь буюу 25 хувь нь эмэгтэй нэр дэвшигчид байв.

“Жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ хэмээн хуульд тодорхойлдог.

Ярилцлагын дугаар бүрт чинь дараалан нэг хүйсийн нэр дэвшигч оролцож байгаа юм биш биз? Эс бөгөөс хэлэлцүүлэгтээ урьсан зочдын жагсаалтад чинь нэг хүйс давамгайлсан, нэг намаас илүү олон хүн оролцсон, өөр өөр албан тушаалтай ч эрх баригч талын мэдээллийг дагнан сурталчлах зорилготой хүмүүсийн нэрс байна уу?

Фото зургууд, видео дүрсэнд чинь сайн талыг нэг хүйс голчлон төлөөлж, муу үйлийг нөгөө хүйс нь илэрхийлсээр байгаа юм биш биз? Эмэгтэй нэр дэвшигчээс хувцас загвар, гэр бүл үр хүүхэд, зан чанарын талаар асуугаад мөрийн хөтөлбөр, бодлого шийдвэрийн талаарх асуултад багахан зай үлдээчихээгүй биз?

Хэвлэл мэдээллийн Ёс зүйн зарчмын гуравдугаарт “Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг

<sup>7</sup> “Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг” Хэвлэлийн Хүрээлэн, 2016 он

баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй” хэмээгээд 3.2-т “Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ” хэмээн байдаг.

Жендэрийн хэвшмэл ойлголтуудыг дэврээхээс аль болох татгалзаж, тэгш байдлаар асуудалд хандах нь зүйтэй. “Жендэрийн хэвшмэл ойлголт” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг хэлдэг. Хэвшмэл ойлголт нь нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдөөд байгаа тогтсон хэлбэрүүд юм. Жишээ нь, “Эмэгтэй хүн байж улстөрч болох хэцүү байна уу”, “Хүчирхэг улстөрч эрэгтэйн ард сайн эхнэр байдаг” зэрэг үг хэллэгээс зайлсхийнэ.

### **Эфир болон зай талбайн тэгш хуваарилалт**

Аливаа улс төрийн нам, нэр дэвшигчийг ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг тэдэнд нь олгох нь хэвлэл мэдээллийн үүрэг юм. Үзэгч, сонсогч, уншигчид мэдээллийг олон талаас хүлээн авах боломжтой болсон нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад өөрийн цензурыг тавьж, хэн хэнд үйлчилж, хэрхэн шударга бус авирлаж буйг төвөггүй мэдэх болсныг сануулах юун.

Мэдээ мэдээллийг бэлтгэхдээ эх сурвалжийн түвшний тэнцвэртэй байдлыг хангах нь чухал. Мэргэжлийн бүлэг, сонирхлын бүлэг, үр дагавар хүртэгсдийн бүлгийг аль алийг нь багтаахыг эрмэлзэх нь мэргэжлийн сэтгүүл зүйн нэг илрэл болно.

Эфирийн цаг, хэвлэлийн зай талбайгаа нам, нэр дэвшигчдэд тэнцвэртэй хуваарилах нь ёс зүйд нийцнэ. Том намууд сурталчилгаанд ихээхэн мөнгө зарцуулж, жижиг нам, бие даагчдад энэ боломж хомс байдаг. Сурталчилгааны гэрээ хийсэн эсэхээс үл хамааран редакц бодлогоороо цөөнхийн дуу хоолой болох, аливаа үзэл бодолд тэнцвэртэй хандах зарчмаа баримтална.

Мөн сонгуулийн үеэрх хэлэлцүүлгийн зочдын жагсаалтдаа энэхүү тэнцвэртэй бодлогоо хадгална.

Сонгуулийн үеэр иргэдийн үзэл бодол, дуу хоолой ихээхэн орхигддог. Редакц үүнд онцгой анхаарч хэлэлцүүлэг, нэвтрүүлэг, мэдээ мэдээлэлдээ багтаана. Энд нам, нэр дэвшигчдээс захиалгаар хийлгэсэн нэвтрүүлэг, нийтлэл дэх иргэдийн дүр багтахгүй.

## 5. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕД СОШИАЛ МЕДИАГ АШИГЛАХ НЬ



Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Цахим орчинд баримтлах редакцын бодлогын баримт бичиг”-ийг гаргасан билээ. Тэрхүү баримт бичгийг редакторууд баримтлан ажиллаж, сонгуулийн үеэр редакцын албан ёсны хуудсууд болон сэтгүүлчдийн үйл ажиллагаагаа зохицуулах нь зүйтэй.

### **Редакц сошиал медиаг ашиглахдаа юуг анхаарах вэ?**

Редакцын албан ёсны сошиал хуудсууд нь тухайн байгууллагын хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй адил хэмжээнд тооцогдох тул сошиалд явагдах үйл ажиллагаа, агуулга нь сэтгүүл зүйн бүтээлийн чанар, шаардлагад нийцсэн байхыг эрмэлзэнэ. Технологийн аюулгүй байдлаа сайтар хангаж, нууц үгээ шаардлагатай үед солих, олон хэрэгслээс нэвтрэхгүй байх, өөр хэрэгслээс нэвтэрсэн үедээ нууц үгийг сануулахгүй байх, log out хийж гарч байх зэргийг анхаарна.

Хэвлэл мэдээллийн байгууллагын нэр дээрх сошиал хаяг нь тухайн редакцыг шууд төлөөлөх тул мэдээллийн хэрэгсэл дээрх “Төлбөртэй мэдээ”, “Үзэл бодол, байр суурь” зэрэг тэмдэглэгээнүүдийг зохих мэдээллүүдэд хэрэглэж, редакцын байр сууринаас ялгана.

### **Сэтгүүлч сошиал медиаг ашиглахдаа юуг анхаарах вэ?**

Редакцад харьяалагддаг сэтгүүлч нь өөрийн сошиал хуудсаараа дамжуулан аль нэгэн нам, нэр дэвшигчийг дэмжих, эс дэмжихээ илэрхийлэх, бусдад санаа бодлоо тулган шаардах, уриалах, санал болгох нь үзэгч, уншигчдыг төөрөгдүүлнэ. Сэтгүүлч хүн улс төрийн хувьд төвийг сахисан байр суурин дээр байх нь ёс зүйтэй. Аль нэг нам, нэр дэвшигчийг дэмжих/эс дэмжих нь сэтгүүл зүйн бүтээлийн хувьд ашиг сонирхлын зөрчилд тооцогдоно. Мөн нэр дэвшигчдийг элдэвлэх нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхэд халдаж буй зохисгүй хэрэг.

Сонгуулийн шуурхай мэдээллийн үед сэтгүүлч аливаа мэдээллийг мэдээллийн



хэрэгсэлдээ нийтлэх/нэвтрүүлэхээс өмнө социал хуудсаараа дамжуулах нь ёс зүйд үл нийцнэ. Хэдийгээр социал хуудас нь албан ёсных биш байсан ч уншигчид редакцын байр суурьтай хольж ойлгох, шуурхай мэдээлэл нь алдаатай байсан тохиолдолд худал мэдээлэл хурдацтай тархах нөхцлийг бүрдүүлнэ.

## 6. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ



Хэвлэл мэдээлэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх болон хариуцлагын талаар тусгасан хуулиудад:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (1998)
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль (2005)
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011)
- Иргэний хууль (2002)
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ (2015)
- Зөрчлийн тухай хууль (2017)

Гэвч эдгээр хууль нь ихэнхдээ хэвлэн нийтлэх эрх чөлөөний эсрэг хэрэглэгдэх байдал анзаарагдаж байна. Глоб Интернэшнл төвөөс гаргасан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчин”-д дурьдсанаар Иргэний хуулийн 21 дүгээр зүйл “Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах” заалтын дагуу 12 хэрэг шийдвэрлэгдсэнээс 11 нь сэтгүүлчийн эсрэг шийдвэр байжээ (2017.01-2018.04 сар хүртэл). Нэхэмжлэгчдийн 33 хувь нь улстөрч, нийтийн албан хаагч байсан бөгөөд нийтийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьсан сэтгүүл зүйн бүтээлийн эсрэг 104.7 сая төгрөгийг нэхэмжилсэн байдаг. Гэтэл “Монгол Улсын 2019 оны Хүний эрхийн тайлан”-д “Глоб интернэшнл” төвөөс 2018-2019 онд явуулсан судалгаагаар 10 сэтгүүлчийн долоо нь ажиллах хугацаандаа дор хаяж нэг удаа төрийн албан хаагчид хуулиар олон нийтэд нээлттэй байх ёстой асуудлаар мэдээлэл авах хүсэлтэд нь хариу өгөөгүй гэж мэдээлжээ” хэмээсэн байдаг.

Мэдээллийн [www.news.mn](http://www.news.mn) сайтад мэдээлснээр “Зөрчлийн тухай хууль хэрэгжиж

эхэлсэн нэг жил гаруйн хугацаанд буюу 2018 оны жилийн эцсийн байдлаар цагдаагийн байгууллагад бусдын нэр хүндэд халдсан, гүтгэсэн гэх зүйл ангитай холбогдуулж 370 орчим гомдол мэдээлэл ирсний 182 нь зөвхөн сэтгүүлчдэд хамаарч байгаа юм. Ингэхдээ улс төрийн өндөр албан тушаалтнуудаас өгсөн гомдол 30 хувийг эзэлжээ”.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тус бүрт хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан байдаг. Сонгуулийн сурталчилгааны үеэр хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаанд Харилцаа холбооны зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар зэрэг байгууллага хяналт тавин ажилладаг. 2016, 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр мэдээллийн сайтуудыг мэдээ мэдээллийнхээ сэтгэгдлийг хаахыг сануулсан байдаг. Гэвч энэ нь ямар хуулиар зохицуулагдсан, ямар ач холбогдолтой болон ямар үндэслэлтэй нь тодорхойгүй.

Энэ мэтээр төрийн байгууллага өөрийн үзэмжээр асуудалд хандаж, зарим хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авч болзошгүй. Тиймээс энэ үед бусад хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцаа холбоотой байж, асуудал, мэдээллээ хуваалцдаг байх нь үүсч болох эрсдэлээс хамгаална. Ялангуяа шинэ тутам байгуулагдсан редакцууд сэтгүүл зүйн салбарын хурал, хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцох нь мэдээлэлтэй болох сайн талтай.

Хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын хүрээнд 2015 оны нэгдүгээр сараас Хэвлэл мэдээллийн зөвлөл үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Хэвлэл мэдээллийн зөвлөл (ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд байгуулагдсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага бөгөөд Радио, телевизийн болон Сонин, сэтгүүл, сайтын гэсэн хоёр Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаа явуулдаг. Ёс зүйн хороод нь тус бүр 15, нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй. Бүлэг бүр нь эзэд, хэвлэн нийтлэгчид, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд болон эвсэл холбоодын ижил тооны төлөөллөөс бүрддэг. Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн хэмээн үзэж буй Монгол Улсын иргэний гомдлыг үнэ төлбөргүй бөгөөд шударгаар хэлэлцэж шийдвэр гаргадаг.

Аливаа асуудал, маргаан шүүх, цагдаагийн байгууллагад очихоос өмнө Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр шийдэгдэх нь мэргэжлийн дүгнэлт гаргадаг сайн талтай. Түүнчлэн ХМЗ нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад зөвлөмж, бодлогын баримт бичгүүдийг боловсруулан хүргэж ажилладаг. Хэвлэл мэдээллийн зөвлөлд иргэд, олон нийтээс “сэтгүүл зүйн тухайлсан байгууллага нь хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн” хэмээх гомдлыг бичгээр болон онлайнгаар ирүүлдэг. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороод нь энгийн үед улирал тутамд, сонгуулийн сурталчилгаа эхэлснээс дуусах хүртэлх хугацаанд долоо хоног тутамд хуралдан, шийдвэр гаргадаг.

Ёс зүйн хороонд иргэд, олон нийтээс гомдол ирсэн даруйд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ажлын албанаас гомдол хаяглагдсан тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын редакцад хариу тайлбар хүссэн албан бичгийг илгээнэ. Тухайн редакц хариу тайлбараа илгээсэн тохиолдолд ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүд хуралдаан эхлэхээс өмнө түүнтэй танилцаж, хуралдааны үеэр редакцын тайлбарыг заавал авч хэлэлцдэг. Тиймээс редакцууд ХМЗ-ийн ажлын албаны хүсэлтэд хариу тайлбараа илгээх нь ёс зүйн хорооны гишүүдэд сэтгүүлчийн үйл ажиллагаа хэрхэн явагдсан талаарх мэдээллийг өгдөг сайн талтай болохыг дурьдах нь зүйтэй.

### **Хэвлэл мэдээллийн зөвлөл**

### **Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй холбоо барих:**

- Хаяг: Чингисийн өргөн чөлөө, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 5-р хороолол, Монгол ТВ тауэр, 11 давхар 1102 тоот-Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн ажлын оффис
- Цахим хаяг: info@mediacouncil.mn
- Утас: 7000-0160
- Вэб сайт: www.mediacouncil.mn

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Сонгуулийн сурталчилгааны үед ажиллах түр журамтай эндээс танилцаарай. <http://www.mediacouncil.mn/a/169>

### **Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн эвлэлээс хуулийн зөвлөгөө, өмгөөлөл үзүүлдэг тул шаардлагатай үед холбоо барих:**

- Хаяг: Сүхбаатар дүүрэг 11 дүгээр хороо 7 дугаар хороолол, Ногоон нуурын гудамж-101 Pro one оффис #402 тоот
- Утас: 330948, 70000948, 99736725
- Имэйл хаяг: mseonline@yahoo.com

### **Хэвлэлийн Хүрээлэнгээс сонгуулийн үйл ажиллагааг сурвалжлах талаар сургалт, гарын авлага, сургалтын материалуудыг боловсруулан түгээх, мөн судалгаа, мониторинг хийдэг тул хандахыг хүсвэл:**

- Хаяг: Сүхбаатар дүүрэг 210620/347, Их тойруу-54, Хэвлэлийн Хүрээлэн НҮТББ
- Утас: 350002, 350003
- Вэб сайт: www.pressinst.org.mn
- Имэйл хаяг: pim@pressinst.org.mn

### **“Глоб интернэшнл” төвөөс хуулийн зөвлөлгөө өгөх, өмгөөлөл үзүүлэх, сонгуулийн үйл ажиллагааг сурвалжлах эрх зүйн болон аюулгүй байдлын чиглэлээр сургалт явуулах, гарын авлага, сургалтын материалуудыг боловсруулан түгээдэг тул хандахыг хүсвэл:**

- Хаяг: Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Их тойруу Логос оффис төв, 902 тоот
- Улаанбаатар - 15141, Шуудангийн салбар - 38, ш/х 102, Монгол улс
- Утас: 324764, 324627
- Вэб сайт: www.globeinter.org.mn
- Имэйл хаяг: globenews@globeinter.org.mn



